



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД
ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА





ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулсан.



Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос дараах журмуудыг баталсан. Үүнд:

01

**2020 ОНЫ
150 ДУГААР
ТОГТООЛ**



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам;

02

**2020 ОНЫ
151 ДҮГЭЭР
ТОГТООЛ**



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

03

**2020 ОНЫ
179 ДҮГЭЭР
ТОГТООЛ**



Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам;

04

**2020 ОНЫ
182 ДУГААР
ТОГТООЛ**



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам;

05

**2020 ОНЫ
1048 ДУГААР
ТОГТООЛ**



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам;

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ



Энэхүү журмын зорилго нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэхэд тавигдах нөхцөл шаардлагыг тодорхойлох, тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг олгох, олгохоос татгалзах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ЖУРМЫН БҮТЭЦ

1

Нийтлэг үндэслэл

2

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага

3

Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

4

Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох

5

Зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох

6

Арилжаа эрхлэх этгээдийн холбогдох бүртгэл

7

Хяналт хариуцлага



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Тусгай зөвшөөрөл гэдэг нь тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг хэлнэ¹.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч этгээд тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

Тайлбар

01

▶ Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа

▶ *Зөвхөн үнэт металл, үнэт чулууг худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхэлнэ.

02

▶ Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа

▶ *Үнэт эдлэл худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхэлнэ.

03

▶ Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа

▶ *Дээрх үйл ажиллагаануудыг хамтад нь эрхлэх боломжтой

¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт.

* Тайлбар хэсэг

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх шаардлагатай. Үүнд:



ХНХ-ИЙН ХЭМЖЭЭ

Нийслэлд үйл ажиллагаа эрхлэх бол


50 сая төгрөг

Аймгийн төвд үйл ажиллагаа эрхлэх бол

25 сая төгрөг

Суманд үйл ажиллагаа эрхлэх бол

5 сая төгрөг



Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч (Үнэт эдлэлийн худалдаа) хуулийн этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байна. Үүнд:



ХНХ-ИЙН ХЭМЖЭЭ

Нийслэлд үйл ажиллагаа эрхлэх бол


10 сая төгрөг

Аймгийн төвд үйл ажиллагаа эрхлэх бол

3 сая төгрөг

Суманд үйл ажиллагаа эрхлэх бол

1 сая төгрөг



03

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, баталгааг ирүүлнэ.

04

Мөн танай компани дараах дүрэм журмуудыг баталсан байх шаардлагатай. Үүнд:

1/ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр¹, мөн 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий гүйлгээ хийсэн харилцагчийн талаарх мэдээллийг хэрхэн зохицуулах болон хэрхэн хөтлөх талаар зохицуулсан дотоод үйл ажиллагааны журмын төсөл;

2/ Дээрх хөтөлбөр болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах ажилтныг томилсон байна. Мөн эрх бүхий албан тушаалтны энэхүү журмын² 12 дугаар хавсралтаар гаргасан хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтыг ирүүлэх шаардлагатай.



ОЙЛГОЛОО. ӨӨР БАРИМТ БИЧИГ ШААРДЛАГАТАЙ ЮУ?

05

Танай байгууллага нь алсын хараа, зорилт зорилгоо тодорхойлсон БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨГ байгууллагын бүтэц зохион байгуулалт, тоног төхөөрөмжийн мэдээллийн хамт ирүүлнэ.

Мөн танай байгууллага нь 2-оос доошгүй ажилтантай байх шаардлагатай бөгөөд гэрээт болон орон тооны бус ажилтан байж болно.



¹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.

² Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам.

06

Мөн та өөрийн үйл ажиллагааг явуулах ажлын байртай байх хэрэгтэй бөгөөд түрээсийн байранд үйл ажиллагаа эрхэлдэг бол ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭГ, харин өөрийн өмчлөлийнх бол ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ГЭРЧИЛГЭЭГ ирүүлнэ. Мөн үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байна¹.



07

Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу холбооноос зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, сертификат авсан байх шаардлагатай².




08

Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох баримт бичиг³;

¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6.
² Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.5.6
³ Хорооны 179 дүгээр тогтоолоор баталсан "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"

➤ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

Салбар, төлөөлөгчийн газар нээх

Оноосон нэр өөрчлөх



ҮМҮЧЭТХЭАЭ*-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд дээрх өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авна.

➤ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

Журмын 9-р хавсралт дахь баримт бичиг

* Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

**Салбар төлөөлөгчийн
газар нээх**

Журмын 10-р хавсралт дахь
баримт бичиг

Оноосон нэр өөрчлөх

Журмын 11-р хавсралт дахь
баримт бичиг

➤ БҮРТГЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ.

- 1/ Эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөх;
- 2/ Арилжаа эрхлэх этгээдийн хаяг өөрчлөгдөх;

➤ БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

**Эрх бүхий албан тушаалтан
өөрчлөгдөх**

Журмын 6-р хавсралт дахь
баримт бичиг

**Арилжаа эрхлэх этгээдийн
хаяг өөрчлөгдөх**

Журмын 13-р хавсралт дахь
баримт бичиг

Холбогдох баримт бичгүүдийг цахимаар болон хэвлэмэл байдлаар Хороонд ирүүлнэ. Дараах зааврын дагуу зөвшөөрлийн цахим системээр холбогдох баримт бичгийг ирүүлээрэй.


➤ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМЭЭР БАРИМТ БИЧИГ ИРҮҮЛЭХ ЗААВАР

АЛХАМ 1

www.frc.mn




ЗӨВШӨӨРЛИЙН
ЦАХИМ СИСТЕМ




АЛХАМ 2

БҮРТГҮҮЛЭХ



АЛХАМ 3

ХЭРЭГЛЭГЧИЙН
НЭР: Байгууллагын
регистрийн дугаар.
Дараагийн талбарт:
И-мэйл хаягийг
оруулна уу.
/нууц үг и-мэйл
хаягаар очно/



АЛХАМ 4

1. Ерөнхий мэдээлэл хэсгийг сонгоно уу.
2. Холбогдох мэдээллийг бүрэн гүйцэд бөглөнө үү.
3. Хадгалах товчийг дарна уу.

САНБАР **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ** ӨРГӨДЛИЙН ЖАГСААЛТ НЭМЭЭЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ ДЭЛГЭЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ

Самбар Ерөнхий мэдээлэл

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хувь хүн эсэх:

Байгууллага

Регистрийн дугаар:

Улсын бүртгэлийн дугаар:

Хүндийн этгээдийн нэр /Монгол/:

Хуулийн этгээдийн нэр /Англи/:

Хариуцлагын хэлбэр:

Үүсгэн байгуулсан огноо:

Харванд орруулалтын хэлбэр:

ХАРИУЦСАН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

Регистр:

Овог:

Нэр:

И-мэйл:

Холбоо барих утас:

Тусламж **Хадгалах**

АЛХАМ 5

Өргөдлийн
жагсаалт



Өргөдөл гаргах
ногоон товчийг
даргах



Салбар, зөвшөөрлийн
төрөл, зөвшөөрлөө
сонгоод хадгална уу.

САНБАР **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ** ӨРГӨДЛИЙН ЖАГСААЛТ НЭМЭЭЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ ДЭЛГЭЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ

Самбар Ерөнхий мэдээлэл **Өргөдлийн жагсаалт**

ӨРГӨДЛИЙН ЖАГСААЛТ

Өргөдөл гаргах Өргөдлийн жагсаалт Өргөдөл гаргах

НЭР

ӨРГӨДӨЛ ГАРГАХ

Хэрэглэгч: 123

Бүртгэсэн огноо: 2021-12-03

Салбар: - Сонгох -

Зөвшөөрлийн төрөл: - Сонгох -


Зөвшөөрөл: - Сонгох -

Тусламж **Хадгалах** Хаах

Энэ хуудсанд 1 - 1. Нийт 1 байна.


АЛХАМ 6

1. Үүссэн өргөдлийг сонгоно уу.
2. Өргөдлийн маягт бөглөх гэсэн товчийг дарна уу.




АЛХАМ 7

1. Цэнхэр баганад байгаа мэдээллийг нэг бүрчлэн бүрэн гүйцэд оруулна уу.
2. Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг дарна уу.




АЛХАМ 8

Файл хавсаргах хэсэг (зөвхөн PDF өргөтгөлтэй файл хавсаргана)



АЛХАМ 9


Өргөдлийн жагсаалт хэсэгт үүсгэсэн хүсэлтээ сонгоод өргөдөл илгээх товчийг дарна уу. Илгээх үед тоон гарын үсэг /token/ шаардлагатай.



АЛХАМ 10

Хэрэв та тоон гарын үсгээ амжилттай бүртгүүлж баримт бичгээ илгээсэн тохиолдолд "ТӨЛӨВ" нь илгээсэн болж өөрчлөгдөнө.

1. Token бүртгүүлэх товчийг дарж тоон гарын үсгээ бүртгүүлэнэ үү.



▶ ИРҮҮЛСЭН БАРИМТ БИЧГИЙГ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ

01

- ▶ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ХҮСЭЛТ ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГИЙГ ХОРООНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМД БОЛОН БИЧИГ ХЭРЭГТ БҮРТГҮҮЛНЭ.

02

- ▶ ХҮСЭЛТИЙГ ЖУРАМД ЗААСАН ХУГАЦААНД ХЯНАНА: /30+14 ХОНОГ/

03

- ▶ ХОРОО ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОНО.

04

- ▶ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХУГАЦААГҮЙГЭЭР ОЛГОХ БӨГӨӨД ТУС ШИЙДВЭРТ ТУХАЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛИЙГ ТОДОРХОЙ ТУСГАНА.

05

- ▶ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОЖ, НЭГДСЭН БҮРТГЭЛД БҮРТГЭНЭ.

06

- ▶ УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛСНЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭХЛҮҮЛСЭНД ТООЦНО. /15 ХОНОГИЙН ДОТОР/

07

- ▶ ХОРОО ЭНЭХҮҮ ЖУРМЫН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.9-Д ЗААСАН ҮНДЭСЛЭЛЭЭР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАНА.¹

¹ Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ



Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт, шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ХЭРЭГЖИЛТ

- 1 Зайны хяналт, шалгалт
- 2 Газар дээрх хяналт, шалгалт
- 3 Мэдээ, тайлан
- 4 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох



ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Газар дээрх хяналт, шалгалтаар арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, журам зааварт нийцэж байгаа эсэхийг газар дээр нь баримтаар тогтоож, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг авна.

ЗАЙНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Зайны хяналт, шалгалтаар салбарын болон арилжаа эрхлэгчийн болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.



ИЖ БҮРЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Баталсан удирдамжийн хүрээнд холбогдох баримт бичигт тулгуурлан арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж, үнэлэлт, дүгнэлт өгнө.

Хорооны 182 дугаар тогтоолоор баталсан журмын 3.6.1-3.6.10 –т заасан баримт бичгийг шаардана

ХЭСЭГЧИЛСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Харилцагчдаас болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж үзсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.



Хэсэгчилсэн хяналт, шалгалтад хамрагдах арилжаа эрхлэгчээс удирдамжид заасан баримт бичгийг шаардана¹.

¹ "Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8.

ЗАЙНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ



Ирүүлсэн тайлан, мэдээг хянаж, үнэлэлт, дүгнэлт өгөх

Тайлан, мэдээг ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, мэдээ шаардлага хангаагүй бол ЭБАТ-д шаардлага тавих

Хугацаатай үүрэг даалгавар өгөх

Шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар, мэдээлэл, холбогдох баримт бичгийг шаардах



ТАЙЛАН, МЭДЭЭГ ХЭЗЭЭ ТАЙЛАГНАХ ЁСТОЙ ВЭ?



ЖИЛИЙН ТАЙЛАН

Дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор



ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

7 дугаар сарын 20-ны дотор



МЭДЭЭ

/1-р улирал/
4 дүгээр сарын 10

/2-р улирал/
7 дугаар сарын 10

/3-р улирал/
10 дугаар сарын 10

/4-р улирал/
01 дүгээр сарын 10



➤ МЭДЭЭ, ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ЗААВАР

1

WWW.FRC.MN
цахим хаяг

2

Цахим
тайлан

3

Мастер
файлаар
илгээх

4

Вебээр
илгээх

МЭДЭЭ, ТАЙЛАН ИРҮҮЛЭХДЭЭ АНХААРВАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ

- ▶ Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаатай холбогдох тайлан, мэдээг тайлагнахгүй байх;
- ▶ Файлын төрөл MS EXCEL 97-2003 байх;
- ▶ Огноог 0000/CC/ӨӨ гэж тэмдэглэх;
0000-он, CC-сар, ӨӨ-өдөр
- ▶ Тайлангийн нэгжийн оронг анхаарах;
- ▶ Нүдэнд аливаа бодолт хийхгүй, зөвхөн гараас анхны утга оруулах;
- ▶ Тайлан, мэдээг илгээхдээ тайлангийн маягтыг тухай бүр www.frc.mn цахим хаягаас шинээр татах;



➤ МЭДЭЭЛЭХ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 4 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 4.1-д “Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй гэж заасан.



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг яаж багасгах вэ?

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДҮҮД хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй.



Ямар гүйлгээг мэдээлэх вэ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-7.5-д заасан гүйлгээг «Санхүүгийн мэдээллийн алба»-д мэдээлнэ.

01



20 САЯ ТӨГРӨГ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ГҮЙЛГЭЭ

Энэ төрлийн бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны мэдээллийг гүйлгээ хийснээс хойш ажлын 5 өдрийн дотор мэдээлэх;

02



СЭЖИГЛЭСЭН ЭСХҮЛ МЭДСЭН

Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон мөнгө гэдгийг сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол 24 цагийн дотор мэдээлэх;

03



Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан этгээд мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлэх;

04



МЭДЭЭЛЭХ

Монголбанкны Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг холбогдох байгууллагад гаргаж өгнө.



WWW.FRC.MN



56-264444



WEBMASTER@FRC.MN



www.facebook.com/FRC.of.Mongolia



Засгийн газрын 4-р байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160